

Монголын залуучуудын улс төрд итгэх итгэл ба сонирхол

Батхишиг Энхчимэг, магистр

Шинжлэх Ухааны Академи, Философийн хүрээлэн

Улаанбаатар, Монгол Улс, b.enkhchimeg90@gmail.com

<https://orcid.org/0009-0004-2180-972X>

Article history

Received : 2025-08-31

Accepted : 2025-11-30

Published : 2025-12-31

Түлхүүр үгс

Улс төр, улс төрийн тогтолцоо, ардчилал, залуучуудын итгэл, сонирхол, оролцоо, үзэл бодол, мэдээ мэдээлэл, тогтворгүй байдал

Хураангуй: Энэхүү өгүүлэл нь Монголын залуучуудын улс төрийн итгэл буурах болон улс төрийн оролцоо сулрахад нөлөөлж буй шалтгаан, нөхцөлүүдийг судлан шинжилсэн болно. Дэлхий даяар хийгдсэн олон судалгаагаар залуучуудын улс төрийн оролцоо буурч, улс төрийн тогтолцоонд итгэх итгэл суларч байна. Улс төрийн байгууллагуудын үйл ажиллагааны доголдол, эдийн засгийн уналт, агаарын бохирдлын нэмэгдэл, цэвэр усны нөөц хомсдох зэрэг нь олон нийтийн дургүйцлийг улам гүнзгийрүүлж байна. Ялангуяа улс төрийн элитүүдийн тансаг хэрэглээ залуучуудын дургүйцлийг төрүүлж, эсэргүүцлийн жагсаал болон зарим тохиолдолд иргэний үймээн самуунд хүргэх нь бий. Эдгээр үйл явдлууд нь шинэ үеийнхний улс төрөөс улам бүр үл итгэх, холдох хандлагыг илэрхийлж байна. Монгол Улсад ч мөн энэ чиг хандлага тодорхой ажиглагдаж байна. Залуучууд улс төрд үл итгэх, улс төрийн нам, төрийн байгууллагад хандах итгэл жилээс жилд буурч байгаа нь судалгаагаар нотлогджээ. Төрийн өндөр албан тушаалтнуудын тансаглал нь зөвхөн Монголд төдийгүй дэлхий дахинаа залуучуудын эсэргүүцлийн гол өдөөгч хүчин зүйл болж байна. Ийнхүү итгэл алдарсан нь улс төрийн засаглалын тогтолцооны гүнзгийрсэн доголдлоос үүдэлтэй бөгөөд тэгш байдлын зарчим алдагдаж, нийгэм-эдийн засгийн ялгаа тэлэхийн хэрээр залуучууд улс төрийн манлайлагчид, институциудад итгэх итгэлээ алдаж байна. Энэхүү судалгаа нь 18–34 насны иргэдийн улс төрд итгэх итгэл, сонирхол, оролцоо болон үзэл санааны чиг баримжааг авч судалсан. Судалгааг Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн шинжлэх ухааны салбараас хэрэгжүүлсэн “Улс төрийн харилцаанд улс төрийн хошуучлалын гүйцэтгэж буй үүрэг, үр нөлөө” (ШУТБИХХЗГ-2022/191) нэртэй суурь судалгаанд тулгуурласан болно.

Mongolian Youth's Trust in Politics and Their Political Interest

Enkhchimeg Batkhishig, MA

Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences

Ulaanbaatar, Mongolia, b.enkhchimeg90@gmail.com

<https://orcid.org/0009-0004-2180-972X>

Key words

Politics, political system, democracy, youth trust, interest, participation, opinions, news, social media, instabilit

© The Author(s), 2025




Abstract: This article explores the underlying causes and conditions contributing to the declining political trust and engagement among Mongolian youth. Globally, numerous studies have shown that young people's participation in politics is waning, accompanied by a weakening trust in political systems. Factors such as dysfunctional political institutions, economic downturns, rising levels of air pollution, and diminishing freshwater resources have exacerbated public dissatisfaction. In particular, the extravagant lifestyles of political elites have sparked outrage among youth, leading to protests and, in some cases, civil unrest. These developments reflect a growing disillusionment with politics among younger generations. In Mongolia, this trend is increasingly evident: youth are becoming politically disengaged, and trust in political parties and state institutions continues to decline year after year. The lavish behavior of those in power has become a focal point of frustration, not only in Mongolia but worldwide, serving as a catalyst for youth-led dissent. This erosion of trust stems from systemic flaws in political governance, where principles of equality are undermined and socioeconomic disparities widen. As a result, young people are losing faith in political leaders and institutions. The analysis focuses on individuals aged 18 to 34 examining their levels of political trust, interest, participation, and ideological orientation. The findings are based on a foundational study conducted by the Philosophy and Political-Legal Sciences Division of the Mongolian Academy of Sciences, titled "The Role and Impact of Political Leadership in Political Relations" (ШУТБИХХЗГ-2022/191)

Олон улсын судалгаанд улс төрийн тогтворгүй байдал нь энгийн болон дундаж амьдралтай залуучуудын улс төрийн оролцоо нэмэгдэх нөхцөл болдог бөгөөд үүнийг Энэтхэг, Непал, Серби зэрэг улс орнуудад гарсан нийгмийн хөдөлгөөнүүдэд ч илэрсэн талаар зарим судлаачид дурдсан байдаг. Жагсаал анхандаа олон сая хэрэглэгчтэй цахим сүлжээнүүдийг хориглох Засгийн газрын шийдвэрийг эсэргүүцэж эхэлсэн. Гэвч аажимдаа эрх баригчдын дунд газар авсан авлигыг эсэргүүцсэн залуусын жагсаал болж хувирсан. Жагсагчдын ихэнх хувийг Z үеийнхэн буюу 13-28 насныхан эзэлж байна гэж орон нутгийн хэвлэлүүд мэдээлжээ (Eagle.mn 2025). Энэ нь зөвхөн Монгол улсын гэлтгүй дэлхий дахинд залуучуудын төрд итгэх итгэл нь суларсантай холбоотой. Олон нийтийн санаа бодол нь болж буй үйл явдлын талаарх ил ба далд хандлагыг

агуулдаг. Түргэн өөрчлөгдөж буй нөхцөл байдалд (байгаль, эдийн засаг, улс төрийн гэх мэт) түргэн шуурхай зохицох шаардлага “олон нийтэд” тулгардагтай холбоотойгоор нийтийн ухамсар үндсэндээ түргэн өөрчлөгддөг хэсгүүдээс бүрддэг. Үүний харьцангуй бага боловч амин чухал хэсгийг “хүмүүсийн зүгээс өөрийгөө хүрээлж буй байгалийн болон нийгмийн орчныг ухамсарлах арга хэлбэр болох сэтгэлгээ” эзэлдэг бөгөөд энэ нь “нийтийн болон нийгмийн ухамсрын суурь” болдог (Геополитик судлалын хүрээлэн 2019-2021). Нийгэмд өрнөж буй үйл явдал бүр цахим орчинд хүчтэй дуулиантай эхэлж намждаг болсон. Цахим орчноос нэгэн зэрэг олон мянган хүн нэгэн зэрэг мэдээлэл авч, дамжуулж өөр өөрсдийн сэтгэгдлээ илэрхийлдэг. Залуучуудын дийлэнх хувь нь цахим орчноос мэдээлэл авдаг болсныг харуулж байна.

Судалгааны арга зүй аргачлалын хувьд Улаанбаатар хот болон сонгогдсон аймаг, сумдын дунд тоон болон чанарын аргыг баримталсан. Судалгааг сорилын судалгаанд түшиглэн дахин засвар хийн боловсруулж Улаанбаатар хотоос 516, хөдөө орон нутгаас 535 нийт 1051 респондентыг хамруулан мэдээлэл цуглуулж ажилласан. Судалгааны түүвэрлэлтийг социологийн энгийн санамсаргүй түүврийн аргыг ашигласны зэрэгцээ Үндэсний статистикийн хорооны (www.1212.mn) сайтын 2022 оны мэдээнд тулгуурлан түүврийн тэнцүү төлөөллийн аргаар бодсон. Ингээд залуучуудын улс төрийн талаарх мэдээллийн эх сурвалж болон улс төрийн мэдээллийг сонирхдог сонирхлын

Зураг 1. Улс төрийн талаарх мэдээллийг сонирхдог байдал




Судалгаанд оролцсон иргэдээс улс төрийн талаарх мэдээллийг хэр сонирхож буйг хувиар илэрхийлэв. Дээрх хүснэгтээс 18-24, 25-34 хүртэлх насны залуучуудын улс төрийн талаарх мэдээллийг сонирхох сонирхолд тулгуурлав. 18-34 насныхан сонирхлын ижил түвшинд байна. Улс төрийн мэдээ мэдээллийг 18-24 насныхыг бодвол 25-34 насныхан 58.8 буюу 19.8 хувийн зөрүүгээр сонирхдоггүй ажээ. Нийгмийн сүлжээ нь мэдээллийг цаг хугацаа, орон

тухайд тоймлон үзүүлбэ. Монголын залуучуудын 18-24 насныхны 10.1 хувь нь олон нийтийн мэдээллийн (телевиз, радио, өдөр тутмын сонин)-оос, нийгмийн сүлжээний хэрэгсэл болон албан ёсны сайтуудаас 44.0 хувь, хамаатан садан, ойр дотнын болон танил хүмүүсээс 17.2 хувь нь мэдээллийг авч байна. Харин 25-34 хүртэлх насны 20.6 хувь нь олон нийтийн мэдээллийн (телевиз, радио, өдөр тутмын сонин)-оос, нийгмийн сүлжээний хэрэгсэл болон албан ёсны сайтуудаас 56 хувь, хамаатан садан, ойр дотнын болон танил хүмүүсээс 26.5 хувь нь улс төрийн талаарх мэдээ мэдээллийг хүлээн авч байна.

зайнаас үл хамааран хурдан шуурхай тархаах, нийгэмд болж буй үйл явдлыг тухай бүрд нь олон хүнд нэгэн зэрэг хүргэж, өөр хоорондоо санал, сэтгэгдлээ солилцох гол хөшүүрэг нь болж байна. Ялангуяа залуучууд нийгмийн сүлжээний хэрэгслийг ашиглан улс төрд оролцох оролцоогоо нэмэгдүүлж байна. Нийгмийн сүлжээгээр дамжуулан үнэн худал мэдээллүүд нэгэн зэрэг урсах бөгөөд иргэд өөрсдөө шүүлтүүртэй хандахыг хичээх болсон. Жишээлбэл,

хэн нэгэн эрх мэдэлтэй, нөлөө бүхий улс төрчдийн гэр бүлийн болон хамаатан садан, найз нөхдийн гадна дотнын их сургуулийн сургалтын төлбөр, аялал, амралт, зугаалга, гоёж гангалах гэх мэт хэрэглээтэй холбоотой үүссэн асуудалд залуучууд эрс эсэргүүцэн орлогоо нотлохыг шаардан сошиалаар аян өрнүүлж, улсынхаа төв талбайд жагсаал цуглаанд оролцдог болсон. Залуучууд үзэл бодлоороо нэгдэн улс орны нөхцөл байдалтай холбоотой санал, хүсэлтээ фэйсбүүк, инстаграмм гэх мэт сүлжээний хэрэгслээр сэтгэгдлээ илэрхийлдэг байна. Мөн emongolia.mn эсэргүүцсэн байр сууриа илэрхийлсэн гарын үсгээ цуглуулж хүргүүлдэг гэх мэтээр оролцож эхэлсэн.

Улс төрд хандах иргэдийн байр суурийг судалгаанд оролцогсдын хүйстэй харьцуулан үзэхэд сонирхогч байр сууринаас хандах иргэдэд 1.4 хувиар хүйсийн ялгарал байсангүй. Шүүмжлэгч байр сууринаас хандах иргэдийн хувьд 11.6 хувийн ялгаа буюу эрэгтэйчүүд илүү зонхилж байна. Дэмжигч бүлгийн иргэдэд хүйсээс шалтгаалсан өөрчлөлт байсангүй. Эмэгтэйчүүд 12.2 хувийн өөрчлөлттэйгөөр огт сонирхохгүй бүлэгт харьяалагдаж байна. Хэлж мэдэхгүй иргэдээс хүйсийн хувьд эмэгтэйчүүд 35.8 хувиар илүү давамгайлж байна.



Зураг 2. Өнөөгийн нийгэмд ардчилал хэр зэрэг хөгжиж буй талаар

Тайлбар: Өнөөгийн нийгэмд ардчилал хөгжиж буй талаар иргэдийн санаа бодлыг ойлгох чиглэлтэй.

Дээрхээс дүгнэвэл өнөөдрийн Монгол улсад ардчилал хөгжлийн бүрэн шатандаа хараахан очоогүй болох нь харагдлаа. 18-24 насны 25.8 хувь нь ардчиллыг хөгжиж буй, мөн хувь нь хөгжихгүй байна гэсэн ижил хувийн саналтай байна. Мөн саарал буюу 13.4 хувь нь дунд зэргээр гэж хариулсан нь 13.4 хувьтай байна. Судалгаанд оролцсон иргэд Монголын ардчиллын хөгжилд саад болж буй хүчин зүйлийг

дараах байдлаар тодорхойлж санал бодлоо илэрхийлжээ. Хамгийн их сөрөг үзүүлэлттэй байгаа хүчин зүйлүүдэд авлига хээл хахууль 14.0 хувиар, өнөөгийн нийгэм дэх шударга бус байдал 12.8 хувь, эрх мэдлийн төлөөх тэмцэл 8.6 хувиар, хууль хэрэгждэггүй байдал 6.5 хувь, улс төрчдийн увайгүй байдал 6.1 хувь, эмх замбараагүй байдал 5.7 хувиар гэх мэтчилэн нөлөөлж байна. Бусад хүчин зүйлс бодлогын хэмжээнд

нөлөөлөхүйц биш бөгөөд нөгөөтэйгөөр тоомжиргүй сул орхих хэрэггүй юм. Залуучуудын улс төрд болоод улс төрийн тогтолцоонд итгэх итгэл нь ардчиллын хөгжил нь манай улсад бүрэн нийцэж буйтай холбоотой.

Хүмүүс залуудаа өөрчлөлтөд нааштай ханддаг бол нас ахихын хэрээр өөрчлөлтөд дургүй болдог. Залуучууд ахмадуудаасаа өөр хандлагатай, нийгмээ өөрчлөх тал дээр илүү эрч хүчтэй байдаг (Миног Кэннот 2019). Монголын

ардчиллын хөгжилд иргэдийн оролцоо утаж байгаа нь олон нийтийн улс төрийн мэдлэг оролцоо, багасахад хүргэж буйн гол шалтгаан болж байна. Энэ нь бодит байдалд ардчиллыг хөгжүүлэхийн тулд улс төрийн соёлыг төлөвшүүлэх, иргэдийн улс төрийн нам болоод төрдөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, идэвхжүүлэхэд чиглэсэн боловсролын бодлого, үнэн зөв мэдээлэл түгээх, улс төрчдийн хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай (Хатанболд О 2024).

№		18-24	25-34	35-44	45-54	55-64	65-аас дээш
1	Орон нутгийн шийдвэр гаргах хуралд оролцох	13.6%	11.4%	25.0%	18.2%	18.2%	13.6%
2	Сонгуульд оролцох	6.3%	21.6%	16.2%	14.4%	22.5%	18.9%
3	Албан ёсоор өргөдөл, гомдол гаргах, санал хүргүүлэх	17.6%	44.1%	14.7%	14.7%	5.9%	2.9%
4	Жагсаал, цуглаанд оролцох	14.9%	28.4%	20.3%	14.9%	17.6%	4.1%
5	УИХ-ын гишүүдтэй биечлэн уулзах	12.5%	16.7%	20.8%	12.5%	12.5%	25.0%
6	Пост, коммент бичих	16.7%	32.2%	16.7%	21.1%	10.0%	3.3%
7	Дээрх бүгд	-	20.0%	60.0%	-	-	20.0%
8	Сонгуулийн сурталчилгаа, кампанит ажилд ухуулагчаар ажилладаг	-	-	33.3%	66.7%	-	-

Хүснэгт 1. Улс төрийн үйл ажиллагаанд оролцдог хэлбэрүүд

18-34 хүртэлх насныхан улс төрийн үйл ажиллагаанд хамгийн түгээмэл оролцдог хэлбэр нь албан ёсоор өргөдөл, гомдол гаргах, санал хүргүүлэх зэргээр түгээмэл оролцож байна. Нийгмийн сүлжээний хэрэгслээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэхдээ пост, коммент бичиж үлдээдэг байна. Харин Сонгуулийн сурталчилгаа, кампанит ажилд оролцдоггүй байна. Эдгээр хэлбэрүүд нь орчин үеийн залуучуудын хамгийн сонгодог аргуудын нэг болсон.

Италийн нэрт эрдэмтэн Вильфредо Парето нь технологийн шинэчлэл бол нийгмийн өөрчлөлт хөгжилд хүргэдэг хэмээн үзжээ. Интернэтийн хөгжил технологийн дэвшил нь нийгэмд удаан хугацааны үр

дагаврыг авчирсан (Pareto V 2023). Энэ ч утгаараа залуучууд улс төрд өөрийн үзэл бодол, байр сууриа социал орчинд

сэтгэгдлээр илэрхийлэх нь нийтлэг байна. Судалгаанд оролцогчдын 15 хувь

нь төр засагтаа итгэдэг гэсэн дүгнэлт гарсан. Төр засагтаа итгэдэг 15 хувийг хамарсан иргэд дараах шалтгаантай байна. Залуучууд улс төр, намуудад

итгэх итгэл нь суларч байгааг дараах хүчин зүйлээс хамаарч байна.

Төр засагтаа итгэдэг шалтгаан

- ✓ Сайжирна гэсэн хүлээлттэй байдаг Итгэхээс өөр аргагүй
- ✓ Төрдөө итгэдэг (Эерэг байр суурь)
- ✓ Улс орны хөгжил, иргэдийн амьдрал төртэй холбоотой учраас итгэнэ
- ✓ Шинэ эрч хүчтэй залуучууд гарч ирвэл улс орон сайжирна
- ✓ Төрийн сүлдэндээ итгэж, залбирдаг Хууль баталж, хэрэгжүүлдэг учраас

- ✓ Улс маань хөгжиж л байна
- ✓ Энэ улсын иргэн учраас
- ✓ Чадахаараа сайн ажиллаж байгаа байх
- ✓ Худал, хуурмаг санагддаг учир
- ✓ Итгэл алдарсан
- ✓ Авлига, хээл хахуульд идэгдсэн
- ✓ Иргэдийн амьдрал өдрөөс өдөрт доройтож байна
- ✓ Ард түмнээ хөсөр хаядаг
- ✓ Төрийн бодлого сул, тогтворгүй
- ✓ Улс орноо асар их өрөнд оруулсан
- ✓ Шударга бус байдал
- ✓ Манай улс хөгжихгүй байна
- ✓ Нэг нь нөгөөгийнхөө хийсэн бүтээснийг үгүй хийдэг
- ✓ Төрийн түшээд чадваргүй
- ✓ Улсын хөрөнгийг хувьдаа завшдаг

Итгэлцэл нь “иргэд төрийн төрийн төлөөлөл бүхий албан хаагчидтай нэг санаа бодол, зорилго чиглэлээр төрийн бодлогыг тодорхойлох хэрэгжүүлэх үйл явц” бөгөөд сайн засаглалын үндэс суурь, ардчилсан үйл явцын хууль ёсны буюу легитим шинж чанарыг харуулж буй юм. (Урандэлгэр Г., Бурмаа С., Алтан-Од М. 2023) Монголын хүний хөгжлийн илтгэлд дурдсанаар залуучуудын улс төрийг сонирхдоггүй, улс төрчдөд итгэдэггүй шалтгаанаа дараах зүйлстэй холбон авч үзсэн байна. Тухайлбал, улс төрчдийн ёс зүйгүй үйлдэл, амлалт, үйл хэргийн зөрүүтэй байдал, намуудад улс төрийн соёл байхгүй, төлөвшөөгүй, зөвхөн эрх мэдлийн төлөөх өрсөлддөг зэрэг нь тэдний итгэлийг алдагдуулдаг гэжээ. “Сонгогчдын оролцоо бага байгаа нь ардчиллын дархлаа сул байгаагийн шинж” гэсэн нь сонгууль ардчилал, түүний хөгжилд хэр ач холбогдолтойг нотолж буй хэрэг юм. Залуучууд ерөнхийдөө улс төрийн тогтолцоонд идэвхгүй байр суурь баримталдаг, сэтгэл дундуур байдаг боловч иргэний нийгэм,

хэвлэл мэдээлэл, спорт, урлаг, соёл, байгаль орчин зэрэг нийгмийн амьдралын олон салбарт идэвхтэй оролцдог. Залуучууд жагсаал цуглаан, эсэргүүцэл хийх зэрэг албан бус, тодорхой зорилготой улс төрийн үйл ажиллагаанд илүү оролцох хандлагатай байдаг (Урандэлгэр Г., Бурмаа С., Алтан-Од М. 2023) Монголын залуучуудын улс төрийн оролцоо сул бөгөөд шийдвэр гаргалтын хүрээнд манлайллын идэвх муу байна. Монгол улсын хөгжилд залуучуудын оролцоо нэн чухал боловч төрд итгэх итгэл алдарсан нь тэдний манлайллын оролцоо сулрахад хүрч байна. Францын эрдэмтэн Жан Жак Руссо (1712-1778)-ийн үзэж буйгаар хамгийн төгс улс төрийн харилцаа бол бүх иргэд нь хуулийг хэлэлцэх болон батлахад оролцох боломжоор хангагдсан бага нутаг дэвсгэртэй, жижиг бүгд найрамдах улс гэж үзэж байв (Ганбаатар Х., Тамир Э., Биндэръяа Д. 2004). Харин Германы эрдэмтэн Эрик Фромм (1900-1980)-ын үзэж буйгаар Оролцоо, түүний бие даасан байдал нь сонирхолтой, чухал ажил бөгөөд санаачилга бүхий оролцооны ардчиллыг бэхжүүлэх нь эрх мэдлийг чухалчлах аюулаас зайлсхийхэд нэн шаардлагатай хэмээсэн байна. Иргэд улс төрд оролцох оролцооны тухай Америкийн эрдэмтэн Жонни Уолкер (1933-2010) төрийн удирдлага, улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй байх нь улс төрд мунхаглалыг дэвэргэдэг. Тиймээс улс төрийн төвшинд иргэд оролцохгүй байх нь улс төрчдөд боломж олгох тэдэнд улс төрийн хуурамч тоглолт хийх боломжийг өндөрсгөдөг учраас ардчилалд туйлын аюултай гэжээ. Иргэдийн оролцоо нь засгийн газрын хариуцлагагүй байдлыг бууруулах, асуудлыг илчлэх, механизмыг сайжруулах сайн талтай (Конрад-Аденауэр сан. 2022).

“Залуучуудын улс төрийн оролцоо” (2016) судалгааны тайланд сонгуульд санал өгч байгаагүй

залуучуудын 17,9% нь насанд хүрээгүй байсан бол үлдсэн 80% гаруй нь итгэл хүлээсэн нам, улс төрч байхгүй, улс төрд итгэдэггүй, улс төр сонирхдоггүй учир оролцдоггүй гэж хариулжээ. 2020 оны судалгаагаар “Аливаа улсын хувьд ардчиллыг бий болгоход сонгууль чөлөөтэй, шударга явагдаж бодит сонголтыг өгөх нь чухал” гэдгийг залуучуудын 98% нь зөв гэж үзсэн ч улс төрийн намуудад 60% сөрөг, УИХ-д 56% сөрөг, ИНБ-д 64% эерэг үнэлгээ өгсөн

байна (journal.num.edu.mn 2023). 2024 оны улс төрийн хошуучлалын судалгаагаар улс төрд идэвхтэйгээр хандах нь 20.4 хувь буюу харьцангуй цөөн хувьтай байна. Хааяа оролцох иргэд 32.6 хувь, улс төрийн холбогдол бүхий үйл ажиллагаанд 47.0 хувь нь оролцдоггүй. Энэ нь залуучуудын улс төрд итгэх итгэл суларсантай холбоотой (Энхчимэг Б 2024).

Хүснэгт 2. Улс төрийн холбогдол бүхий үйл ажиллагаанд оролцдог шалтгаан (хувиар)

№	Идэвхтэй шалтгаан	Хувь	Идэвхгүй оролцдог шалтгаан	Хувь
1	Иргэн хүнийхээ үүргийг биелүүлдэг	34.6	Оролцох шаардлага гардаггүй, оролцох шаардлагагүй гэж боддог	24.6
2	Сонгуульд саналаа өгөх гэж оролцдог	19.6	Цаг зав муутай учраас оролцдоггүй	23.4
3	Сонгуулийн судалгаа, сурталчилгаанд оролцдог	9.8	Итгэл даах нэр дэвшигч байхгүй учраас	9.1
4	Намын гишүүн учраас	7.5	Сонгуулиас бусад үйл ажиллагаанд оролцдоггүй	4.0
5	Баг, хорооноос улс төрийн хурал цуглаанд оролцохыг уриалж шаарддаг	6.5	Ажлын үр дүнгүй, иргэдийнхээ итгэлийг хугалсан	3.6
6	Үзэл бодлоо илэрхийлэх	3.3	Улс төрийн мэдлэг дутмаг	2.6
7	Нийгэмтэй ойр байж хүмүүстэй уулзах	1.9	Оролцуулдаггүй	1.8
8	Албан үүргийнхээ дагуу	1.9	Намын гишүүд л оролцдог байх гэж боддог	0.8
9	Улс төрийг сонирхдог	1.4	Хариулж мэдэхгүй	13.9
10	Хариулж мэдэхгүй	7.0	Хариулахаас татгалзсан	16.0
11	Хариулахаас татгалзсан	6.5	-	-
Нийт		100.0	Нийт	100.0

Судалгаанд оролцогчдоос холбогдол бүхий үйл ажиллагаанд оролцох байдлыг идэвхтэй, идэвхгүй шалтгаанаар ангилал үүсгэн эрэмбэлэв. **Идэвхтэй оролцдог** шалтгаанаас үндсэн 3 хүчин зүйлийг нэрлэвэл 1. Иргэн хүнийхээ үүргийг биелүүлдэг (34.6%), 2. Сонгуульд саналаа өгөх гэж оролцдог (19.6%), 3. Сонгуулийн судалгаа, сурталчилгаанд оролцдог (9.8%) зэрэг байна. Улс төрийн холбогдол бүхий үйл ажиллагаанд **идэвхгүй оролцдог** шалтгаанаас үндсэн 3 хүчин зүйлийг нэрлэвэл 1. оролцох шаардлага гардаггүй, оролцох шаардлагагүй гэж

боддог (24.6%), 2. цаг зав муутай учраас оролцдоггүй учраас (23.4%), итгэл даах нэр дэвшигч байхгүй учраас (9.1%) гэсэн шалтгаан нөлөөлж байна. Мөн залуучуудын оролцоог намын гишүүнчлэлээр харгалзан үзэхийг оролдсон. Залуучуудын хувьд аль нэг намын гишүүн мөн бол ямар намд элссэн болохыг тодруулав. Монгол ардын намын гишүүн 65.9 хувь байгаа бөгөөд тус намын үйл ажиллагааг дэмждэг, ардчилсан намын харьяалалтай гишүүд 29.0 хувь, ХҮН-д 3.8 хувь, шинэ намд 0.6 хувь нь гишүүнчлэлтэй байна.

№	Өнгүүд	Шалтгаан
1	Хар саарал	Улс орны өнөөгийн нөхцөл байдалд үнийн өсөлт, авлига хээл хахууль, намчирхал, гэмт хэргийн гаралт нэмэгдэж буй зэргээс шалтгаалж байгаа учраас хар бараан өнгөөр илэрхийлжээ.
2	Цэнхэр	Улсын төрийн тогтворгүй бодлого, ард иргэдийн амьдрал тааруу түвшинд байгаа хэдий ч ирээдүйд сайжирна гэсэн хүлээлтээс шалтгаалж байна.
3	Ногоон	Улс орны нөхцөл байдал сайжирч дээшлэхийг хүсэж мөнгөний өнгийг билэгдэж тус өнгөөр илэрхийлсэн байна.
4	Цагаан	Улс төрийн өнөөгийн нөхцөл илүү сайжирна гэсэн хүлээлттэй байгаа. Ирээдүйг гэрэл гэгээтэй байгаасай гэж хүсдэг.
5	Солонгон өнгө	Улс төрийн удирдлагууд болон бодлого шийдвэрүүд өөрчлөгдөж, олон гишүүдтэй олж тус бүрдээ өөр өөрийн ажил хэрэг явуулдаг болохоор.

Хүснэгт 3. Өнөөгийн улс төрийн нөхцөл байдлыг өнгөөр илэрхийлсэн байдлыг эрэмбэлэв.

Эх сурвалж: Улс төр эрх зүйн салбар. Философийн хүрээлэн. ШУА. “Улс төрийн харилцаанд хошуучлалын гүйцэтгэх үүрэг, үр нөлөө, үр дагавар. Олон нийтийн санаа бодлын судалгаа. УБ., 2023

Улс төрийн амьдралд залуу үеийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн улс төрийн боловсролыг сайжруулах нь улс төрийн үйл явцын чанарыг дээшлүүлэхэд чухал алхам мөн. Улс төртэй холбоотой зарим процесс нь нөхцөл байдлаас шалтгаалан нийгэмд, ялангуяа цахим орчинд эерэг, сөрөг янз бүрийн байдлаар тархдаг. Эдгээр тархсан үйл явдал дунд нэг нь нөгөөгөөрөө дарагдаж замхран арилдаг. Залуучууд идэвхгүй, улс төрийг угаасаа сонирхдоггүй биш юм. Харин яг хэрэгцээт цаг мөчид тэд өөрсдийн дуу хоолойг илэрхийлэн жагсаал, цуглаанд оролцоот ч болов улс төрийн сонирхлоо харуулдаг. Залуучуудад улс төрийн тогтолцоо таалагддаггүй. Итгэл

үзүүлсэн улс төрч төрч нь дорвитой ажиллахгүй мөн улсын эдийн засгийн уналт, инфляц зэрэг олон асуудлууд нь тэдэнд таалагддаггүй. Залуучууд интернэт, Twitter, Facebook зэрэг нийгмийн цахим сүлжээг идэвхтэй ашиглаж байна. Хэвлэл мэдээллийн шинэ хэрэгслийг залуучууд ихэвчлэн чөлөөт цагаа өнгөрүүлэхэд ашиглаж байгаа ч тэдний хувьд энэ нь мэдээллийн гол эх сурвалж болж, үзэл бодлоо илэрхийлэх боломжийг нээжээ.

Улс төрийн оролцоог олон төрлийн хэлбэрээр ойлгох ба хамгийн түгээмэл буюу ойлголт буюу ашигладаг төрөл нь сонгуульд оролцох оролцоо юм. Мөн аливаа намын үйл ажиллагаанд оролцох, иргэд залуу, дунд үе, хөгшид

гэлтгүйгээр өөрсдийн тааламжит амьдралын төлөө үзэл бодлоо дуу нэгтгийгээр төрд илэрхийлэх нь оролцооны хамгийн энгийн төрлүүдийн нэг юм. Улс төрд оролцох оролцоо нь нас, хүйс үл харгалзан ахмад үе, дунд үе, залуу үе гэхгүйгээр ижил түвшинд оролцож байж нийгмийн амьдрал сайжирдаг. Гэвч өнөөгийн нийгэмд бодит байдал дээр дунд ба ахмад үеийнхэн оролцоо сайтай байдаг. Энэ нь залуучуудын улс төрийн итгэл суларсантай холбоотой. Улс төрийн оролцоо нь хэн бүхний сайн мэдэж байгааг сонгуульд оролцох оролцоо нь байдаг.

Энэ байдлын хувьд залуу хүн гэхээсээ урьтаж иргэн хүний хувьд

ДҮГНЭЛТ

Орчин үеийн залуучуудын улс төрд итгэх итгэл, сонирхол, оролцоо нь улс орны нийгэм, эдийн засгийн байдал, боловсролын түвшин, мэдээллийн хүртээмж, улс төрийн орчин зэрэг хүчин зүйлээс хамаардаг. Манай улсад залуучуудын улс төрийн оролцоо жил ирэх тусам буурч байгаа бөгөөд улс төрд итгэх итгэл ч аажмаар сулрах болсон. Улс төрийн байгууллагууд, засгийн газрууд шударга бус эсвэл үр ашиггүй гэж үзэх хандлагатай байна. Мөн Авлигын асуудал, улс төрийн намуудын хоорондын зөрчил, сонгуулийн будилаан, улс төрийн тогтолцоо, инфляц, үнийн өсөлт зэрэг томоохон бодлогын хэрэгжилттэй холбоотой асуудлууд залуучуудын итгэл алдрах шалтгаанууд болж байна. Үүнээс гадна сүүлийн жилүүдэд баян ядуугийн ялгарал үүсэх хандлагатай болж байна. Улс төрчдийн хувийн ашиг сонирхлоос үүдэлтэй шударга бус үйлдлүүд нь монголын залуучуудын төрдөө итгэл итгэлийг сулруулж, жагсаал цуглаан зохион байгуулж үзэл бодлоороо нэгдэн төрдөө эсэргүүцэж буйгаа илэрхийлэх болсон. Энэ нь тэдний хувьд хамгийн зоригтой,

оролцоотой хандах нэг шалтгаан болж байгаа юм. Иргэн хүний хувьд өөрийн гэсэн итгэл үнэмшилтэй, үзэл бодолтой, зорилготой байх нь энэ бүхнээ хэрэгжүүлэх гол хүчин зүйл нь болж байгаа юм.

Санхүүжилт: Монгол Улсын Боловсрол, Шинжлэх Ухааны яамны захиалгаар ШУТС-ийн санхүүжилтээр ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарт доктор (Ph.D), ЭШТА О.Хатанболд удирдагчтай 2022-2024 онд *«Улс төрийн харилцаан дахь улс төрийн хошуучлалын гүйцэтгэж буй үүрэг, үр нөлөө»* сэдэвт (ШУТБИХХЗГ-2022/191) суурь судалгааны төсөл хэрэгжсэн.

шийдэмгий, мөн улс төр дэх оролцооны байр сууриа батлан харуулж буй үйлдэл мөн.

Залуучууд уламжлалт гэгдэх улс төрийн оролцоо буюу сонгуульд саналаа өгөх, намд элсэх гэх мэтээр төсөөлж оролцоот байдлаа энэ аргаар илэрхийлдэг байсан. Харин техник технологи хөгжиж цахим хувилбарт шилжсэнээр шинэ хэлбэрийн буюу нийгмийн сүлжээ ашиглан үзэл бодлоо илэрхийлэх арга руу нэвтэрсэн байна. Тус шинэ хэлбэрийн оролцоо болох нийгмийн сүлжээний хэрэгслээр дамжуулан нэгэндээ зориулсан үгээ постлох, хэн нэгнийг дэмжиж буйгаа хэлэх, бие биеэ жагсаал, цуглаанд оролцохыг хүсэх, ятгах зэрэг байдлаар оролцож байна. үүнээс үүдэлтэй сөрөг хүчнүүд “тролл” гэгчийг хүчтэй ашиглах болсон байна. Интернэт болон нийгмийн сүлжээнүүд залуучуудын мэдээлэл авах, улс төрийн асуудлаар санал бодлоо солилцох боломжийг өргөжүүлсэн. Гэхдээ хуурамч мэдээлэл, хэт туйлширсан үзэл суртал нь залуучуудын улс төрийн мэдлэг болон хандлагыг сөргөөр нөлөөлөх тохиолдол ч байдаг

болсон цаг үе ирээд байна. Мөн Боловсрол ба улс төрийн оролцоо гэдэг салшгүй харилцан хамааралтай болоод удаж буй. Боловсролын түвшин өндөр байх тусам залуучуудын улс төрийн идэвх, оролцоо илүү байдаг. боловсролын түвшин түвшин нэмэгдэхийн хэрээр улс төрийн ойлголт, сонирхол, оролцоонд эерэг хандлага ажиглагдаж байна. залуучууд илүү ил тод, хариуцлагатай, тогтвортой засаглалыг хүсдэг байна. Орчин үеийн залуучууд улс төрд итгэх итгэл, сонирхлын талаар идэвхтэй харилцаж, шинэ санаачилгыг дэмжих сонирхолтой байдаг ч тэдний оролцоо болон хандлагыг эергээр хөгжүүлэхэд төр, нийгмийн байгууллагуудын зүгээс дэмжлэг шаардлагатай гэж үзэж байна.

Ашигласан материал

- Eagle.mn. 2025. *Балба улсын Z үеийнхэн Засгийн газрын эсрэг жагсаал хийж байна.* Ганчимэг Г. 8 10. <https://eagle.mn/r/S63FHluY8KK>.
- journal.num.edu.mn. 2023. *Бизнес ба Инноваци*. Монголын залуучуудын улс төрийн сонголтод нөлөөлөх хүчин зүйлс. <https://doi.org/10.22353/jbai.2023090210>
- Pareto V. 2023. <https://www.britannica.com/topic/social-change->.
- Геополитик судлалын хүрээлэн. 2019-2021. ““монгол улсын улс төр, эдийн засаг, нийгмийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн судалгаа” Суурь судалгааны төслийн тайлан.” 77.
- Миного Кэнног. 2019. “Улс төрийн туршлага/улс төр:тун товчхон танилцуулга.” орчуулсан Ариунсанаа Т, 75. Уб: Мөнхийн үсэг.
- Урандэлгэр Г., Бурмаа С., Алтан-Од М. 2023. “Монголын залуучуудын улс төрийн сонголтод нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа.” *Бизнес ба Инноваци* 9 (2): 143. <https://doi.org/10.22353/jbai.2023090210>
- Урандэлгэр Г., Бурмаа С., Алтан-Од М. 2023. “Монголын залуучуудын улс төрийн сонголтод нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа.” *Бизнес ба Инноваци* 9 (2): 143. <https://doi.org/10.22353/jbai.2023090210>
- Хатанболд О. 2024. “Монгол дахь улс төрийн хошуучлал: өнөөгийн төлөв хандлага.” *XXI зууны Монголын улс төрийн хошуучлал: онцлог, хэв маяг, төлөв хандлага*-Д, Төмөр-Очир Ред: Батхишиг Б.-ээр, 376. Уб: Соёмбо принтинг ххк.
- Энхчимэг Б. 2024. “XXI зууны Монголын улс төрийн хошуучлал: онцлог, хэв маяг, төлөв хандлага.” *Монгол дахь улс төрийн хошуучлал: өнөөгийн төлөв хандлага*-Д, Төмөр-Очир С Батхишиг Б.-ээр, 232. Уб: Соёмбо принтинг ххк.